ХАРАА, ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХИ ЭКСПЕРТИЙН САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ (Захиалагч УИХ-ын гишүүн Д.Арвин)

Ц. Товуусүрэн, А. Пагма ... бусад

Удирдамж

БАТЛАВ. УИХТГ-ын Судалгааны төвийн дарга Ц. Норовдондог (Ph.D)

УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны захиалгаар хийгдэж буй “Хараа, хяналтгүй хүүхдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаархи экспертийн санал асуулгын судалгаа, дүн шинжилгээ” сэдэвт экспертийн санал асуулгын судалгааны удирдамж

1. Зорилго.

Монголын ирээдүй болсон хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгох, ялангуяа хараа хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар энэ асуудлыг хариуцан ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудын саналыг авч нэгтгэн боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

2. Гүйцэтгэгч баг

Багийн ахлагч: Ахлах референт Ц. Товуусүрэн
Багийн гишүүд:

1.	А. Пагма	Хүүхдийн хаяг тогтоох төв	5 хүн
2.	С. Дорждагва	ХУД-ийн зарим хорооны нийгмийн ажилтан	5 хүн
3.	Ч. Базар	СХД-ийн зарим хорооны нийгмийн ажилтан	5 хүн
4.	Г. Чулуун	БГД-ийн зарим хорооны нийгмийн ажилтан	5 хүн
5.	Н. Түвшинтөгс	БЗД-ийн зарим хорооны нийгмийн ажилтан	5 хүн
6.	Р. Батсүх	Налайх дүүргийн зарим хорооны нийгмийн ажилтан	5 хүн
7.	Б. Мөнхцэцэг	Нийслэлийн Хүүхдийн халамж үйлчилгээний төв	5 хүн
8.	Д. Мягмарцэрэн	Нийслэлийн хүүхдийн төлөө газар, Кристина Нобелийн Нархан хотхон	5 хүн
9.	Т. Мягмаржав	Засгийн газрын агентлаг-Хүүхдийн төлөө газар, ХАХТ-ын цэцэрлэг	5 хүн
10.	Ц. Батбаяр	НХХЯам, Нялхсын клиник сувилал	5 хүн
11.	Л. Батжав	Нийслэлийн Цагдаагийн газрын Хүүхдийн алба	5 хүн
12.	Ч. Онончимэг	Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв, СБД-ийн Цагдаагийн Хүүхдийн алба	5 хүн
13.	О. Нарантуяа	“Альфа коммутиз” ОУ-ын “Өнөр”, “Эрдэнэ” төв, ЧД-ийн Цагдаагийн Хүүхдийн алба	5 хүн

14.	П. Амаржаргал	Монголын хүүхдийн сангийн “Гэр бүл”1.2.3. төв Японы хүүхдийг ивээх сан	5 хүн
15.	Б. Хатантуул	Өгөөмөр/Фратерните Норте/, Тэмүүлэл /Оюунтүлхүүр сан/ асрамжийн төв, БЗД-ийн Цагдаагийн хүүхдийн алба	5 хүн
16.	Д. Жигваагүнсэл	ХУД-ийн Цагдаагийн Хүүхдийн алба, “Гэрэлт өргөө” 1.2.3./ДЗОУБ/	5 хүн
17.	Б. Ариунжаргал	БГД-ийн Цагдаагийн Хүүхдийн алба, Вербист төв	5 хүн
18.	Д. Гэрэл	Англиин хүүхдийг ивээх сан, Хүүхдийн хөдөлмөрийн Тэвчишгүй хэлбэрийн эсрэг үндэсний сүлжээ	5 хүн
19.	Ц. Батдорж	СХД-ийн Цагдаагийн Хүүхдийн алба,”Бадамлянхуа” Халамжийн төв	5 хүн
20.	Г. Билгээ	Хүүхэд асран хүмүүжүүлэх төв	5 хүн
21.	Ц. Болормаа	Хүүхдийн эрхийн Үндэсний төв, “СОС” хотхон	5 хүн
22.	Ө. өнхтунгалаг	Амьдрах ухаан сургалт, үйлдвэрлэлийн төв, “Өсөх нахиа” асрамжийн төв	5 хүн
23.	Ц. Элбэгзаяа	Налайх дүүргийн Хүүхдийн цагдаагийн алба, Хүүхдийн халамжийн төв	5 хүн
БҮГД		115 респондент	

3. Хамрах хүрээ:

Судалгааг Улаанбаатар хотод явуулах бөгөөд НХХЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар, Нийслэлийн хүүхдийн төлөө газар, Нийслэлийн хүүхдийн халамж, үйдчилгээний газар, Нийслэлийн цагдаагийн газар, дүүргүүдийн цагдаагийн газар, Хүүхдийн хаяг тогтоох төв, нийслэлийн зарим хороод, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын тус асуудлыг хариуцсан ажилтнууд хамрагдана.

4. Хугацаа:

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2011 оны 01 сарын 07-ны өдрөөс эхлэн 2011 оны 01 сарын 14- ны хооронд явуулж нэгдсэн тайланг 2011 оны 01 сарын 20- ний өдөр захиалагчид хүлээлгэн өгнө.

5. Судалгааны арга зүй.

Экспертийн түвшинд анкет асуулгын аргыг судалгаанд хэрэглэнэ.

6. Судалгаагаар хийгдэх ажил

Судлаач бүр урьдчилан бэлтгэсэн судалгааны хэрэглэгдэхүүнийг ашиглан холбогдох мэдээллийг авна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын асуудлыг хариуцсан газруудад түүвэр социологийн санал асуулгыг мэргэжлийн байгууллагын экспертийн дунд явуулах:
- НХХЯ-ны уг асуудлыг хариуцсан мэргэжилтэн 3 хүнээс судалгааны мэдээлэл авах,
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар- 5 хүнээс судалгааны мэдээлэл авах,
- Нийслэлийн хүүхдийн төлөө газар-5 хүнээс судалгааны мэдээлэл авах,

- Нийслэлийн хүүхдийн халамж, үйдчилгээний газар-5 хүнээс судалгааны мэдээлэл авах,
- Нийслэлийн цагдаагийн газар-2 хүн
- Дүүргийн цагдаагийн газрын хүүхдийн байцаагч- тус бүр 3 хүн, нийт 18 хүн
- Хүүхдийн хаяг тогтоох төв-5 хүн
- Сонгино хайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүргийн 5 хорооны нийгмийн ажилтан нийт 30 хүн
- Хүүхэд хамгааллын асуудлаар үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын нийт 15 хүн
- Нийслэлийн хүүхдийн халамжийн төвүүд- 15 хүн, нийт 115 хүн

Гарах үр дүн:

- Хараа хяналтгүй хүүхдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаарх экспертийн санал асуулгын дүнг нэгтгэн боловсруулж УИХ-ын НББСШУ-ны Байнгын хороонд хүргүүлэх,
- Мэдээллийн нэгдсэн сан бий болгох

* * *

УДИРТГАЛ

Хараа, хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаархи экспертийн санал асуулгын судалгаа, дүн шинжилгээ" сэдэвт судалгааны ажлыг УИХ-ын гишүүн Д.Арвины захиалгаар УИХ-ын Тамгын Газрын Судалгааны төвийн судлаачдын баг гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Монгол Улсын ирээдүй болсон хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгох, ялангуяа хараа хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар энэ асуудлыг хариуцан ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудын саналыг авч нэгтгэн боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны агуулга:

1. Хараа, хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаархи экспертүүдийн санаа, бодол
2. Хараа, хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаархи санал асуулгын судалгааны дүгнэлт

Судалгааны аргачлал:

Судалгааг экспертийн түвшинд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудаас санал асуулгын аргаар санал, бодлыг нь судлах аргаар явуулсан.

Судалгааны анхдагч мэдээллийг цуглуулах ажлыг Судалгааны төвийн нийт 23 шинжээч, судлаачид судлаачид Улаанбаатар хотын 6 дүүрэг, Налайх дүүргийн хороод, төрийн болон хувийн хэвшил, ОУ-ын болон буяны байгууллагын дэмжлэгтэй ажилладаг 35 халамж, асрамжийн газар дээр очиж танилцах, экспертийг сонгох, санал асуулгын хуудас бөглүүлэх замаар хийлээ. Санал асуулгын цуглуулсан анхдагч социологийн мэдээллийг статистикийн боловсруулалтын SPSS-12 багц программаар боловсруулан нэгтгэн дүгнэсэн.

Хамрах хүрээ

Судалгааг Улаанбаатар хотод 2011 оны 01 сарын 07-оос 01 дүгээр сарын 14-ны өдрүүдэд явуулсан бөгөөд НХХЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар, Нийслэлийн хүүхдийн төлөө газар, Нийслэлийн хүүхдийн халамж, үйлчилгээний газар, Нийслэлийн цагдаагийн газар, дүүргүүдийн цагдаагийн газар, Хүүхдийн хаяг тогтоох төв, нийслэлийн зарим хороод, хүүхэд хамгаалллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын тус асуудлыг хариуцсан ажилтнууд нийт 117 респондент хамрагдсан.

Судалгааны ажлын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагаа хийгдсэн болно. Үүнд:

- Судалгаанд шаардагдах үндсэн хэрэглэгдэхүүнийг урьдчилан боловсруулж бэлтгэсэн
- Бодлого, эрх зүйн баримт бичгүүдийг сонгож харьцуулсан шинжилгээ хийсэн
- Мэдээлэл цуглуулах ажил зохион байгуулж судалгааны багийн гишүүдэд семинар зохион байгуулсан
- Цуглуулсан мэдээлэлд нэгдсэн боловсруулалт хийсэн
- Судалгааны материалыг нэгтгэн дүгнэж, судалгааны тайлан бичсэн

Судалгааны ажлыг Судалгааны төвийн ахлах референт Ц. Товуусүрэн ахалж, судалгааны мэдээллийг авах ажилд төвийн шинжээч, судлаачид ажиллаж, судалгааны техник ажил, дан тооллыг боловсруулах ажлыг судлаач Ө. Мөнхтунгалаг, Б. Ариунжаргал нар хийсэн ба судалгааны мэдээллийг нэгтгэн дүгнэж боловсруулах, нэгдсэн тайлан бичих ажлыг шинжээч А. Пагма хийж гүйцэтгэв.

* * *

1. ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХИ ЭКСПЕРТҮҮДИЙН САНАА, БОДОЛ

Судалгааны гол зорилго нь Монгол Улсын ирээдүй болсон хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгох, ялангуяа хараа, хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар энэ асуудлыг хариуцан ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудын саналыг авч нэгтгэн боловсруулж, дүгнэлт хийх явдал юм.

Хараа, хяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй 16 хүртэлх насны, хаяг, эцэг эх, харгалзан дэмжигч нь тодорхойгүй хүүхдийг хараа хяналтгүй хүүхэд гэж нэрлэдэг. Монгол Улсад гэр бүл, хүүхдийн эрхийн хамгаалллын харилцааг 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, 1994 оны Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль, 1996 оны Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 1999 оны Монгол улсын Гэр бүлийн тухай хууль, 2002 оны Иргэний болон 2004 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг хуулиар зохицуулж байна.

Судалгааны үр дүн:

Судалгаанд юуны өмнө манай улсад хүүхдийн талаар явуулж байгаа төрийн бодлогын хэрэгжилт, хүүхэд хамгаалын нэгдсэн тогтолцоо бүрдсэн эсэх талаар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын экспертүүдийн санаа бодлыг тандан судлахад чиглэгдсэн болно.

1. “Хүүхэд хамгаалллын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилт ерөнхийдөө ямар байна гэж Та боддог вэ?” гэсэн асуултад нийт судалгаанд хамрагдсан 117 экспертийн 7.6 хувь нь хэрэгжилт сайн байгаа, 46.6 хувь нь дунд зэрэг, 33.1 хувь нь

тааруухан, 6.8 хувь нь муу, 5.9 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

2. “Хүүхэд хамгааллын салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх талаар дараахь байгууллагууд хэр ажиллаж байна гэж Та үзэж байна вэ?” гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ.

Хүснэгт 1

Байгууллагуудын нэр	Үйл ажиллагааны үнэлгээ				
	Сайн ажиллаж байна	Дунд зэрэг ажиллаж байна	Тааруухан ажиллаж байна	Маш муу ажилладаг	Мэдэхгүй
ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар	17.9%	40.2%	25.0%	8.9%	8.0%
Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар	10.8%	32.4%	33.3%	12.6%	10.8%
Дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар	11.6%	26.8%	35.7%	18.8%	7.1%
Нийслэлийн хүүхдийн төлөө газар	33.6%	37.3%	19.1%	7.3%	2.7%
Нийслэлийн хүүхдийн халамж үйлчилгээний төв	21.1%	40.4%	18.4%	8.8%	11.4%
Цагдаагийн байгууллага	31.9%	43.4%	17.7%	4.4%	2.7%
Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ	28.9%	38.6%	11.4%	6.1%	14.9%

Эндээс үзвэл судалгаанд хамрагдсан экспертүүд энэ салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт дунд зэрэг, тааруухан байна гэсэн үнэлгээ өгч байгаа бол хүүхдийн эрхийг хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг мөн л дунд зэрэг, тааруухан ажиллаж байна гэж үнэлжээ.

3. “Манай улсад хүүхдийн эрх олон хэлбэрээр зөрчигдөж байгаа нь манайд хүүхэд хамгааллын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байгааг харуулж байна гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэсэн асуултад 45.3 хувь нь санал бүрэн нийлнэ, 50.4 хувь нь санал нийлнэ, 4.3 хувь нь санал нийлэхгүй гэсэн хариултыг өгсөн байна. Үүнийг диаграммаар үзүүлбэл: (График 1 -ийг үзнэ үү)

Түүнчлэн судалгаанд хамрагдсан экспертүүд хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд хамгийн үр дүнтэй хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийг нэрлэсэн бөгөөд нийт 30 төсөл, хөтөлбөрийг нэрлэсэнээс “Хүүхэд хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, Нийслэлийн ХХХТХ-ийг устгах дэд хөтөлбөр, “Дэлхийн зөн” байгууллагын Хүүхэд хамгааллын хөтөлбөр, Нийслэлийн нутаг дэвсгэрт АЙПЕК хөдөлмөрийн байгууллагаас санхүүжүүлэн 2007-2010 онд хэрэгжсэн төсөл, Гэртээ харих замд зэрэг төсөл, арга хэмжээг хамгийн олон удаа дурьдсан байна.



График 1

4. Судалгааны асуулгын явцад бид хүүхдийн эрхийг хамгаалах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, төсөл , хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар олон нийт хэр мэдээлэлтэй байдаг, хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд болон хараа хяналтгүй хүүхдийг халамжлах төвүүдийн үйл ажиллагаа хэр зэрэг уялдаа, холбоотой байдгийг тодруулах үүднээс тавьсан “Хүүхэд хамгааллын салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх тайлан мэдээлэлтэй танилцах бололцоо Танд хэр зэрэг байдаг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 30.8 хувь нь бүрэн боломжтой, 48.7 хувь нь хөөцөлдөж байж л танилцах боломжтой, 13.7 хувь нь бараг боломжгүй, 5.1 хувь нь тийм боломж ерөөсөө байхгүй, 1.7 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

5. “Таны бодлоор хараа хяналтгүй хүүхдийг халамжлах төвүүд, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага хоёрын ажлын уялдаа холбоо ямар байдаг вэ?” гэсэн асуултад респондентуудын 15.7 хувь нь сайн байгаа, 31.3 хувь нь дунд зэрэг, 32.2 хувь нь тааруухан, 15.7 хувь нь муу байгаа, 5.2 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг тус тус өгчээ.

Энэхүү судалгааны нэг үндсэн зорилго нь хараа, хяналтгүй хүүхдүүдийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар экспертүүдийн санаа, бодлыг тодруулах явдал юм. Энэ зорилгоор бид дараах бүлэг асуудлыг респодентуудад тавьж хариултыг авсан болно.

6. Өнөө үед хүүхдүүд ямар шалтгааны улмаас гэр орон, эх эцгээсээ дайжин гудамжинд тэнэмэл амьдралаар амьдрах болсон шалтгааныг экспертүүд юу гэж үзэж байгааг тандан “Эх хүн үр хүүхдээ ямар шалтгаанаас болж гудамжинд хаядаг гэж Та үздэг вэ?”гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 57.8 хувь нь хүүхдээ тэжээн тэтгэх эдийн засгийн боломжгүйгээс, 17.8 хувь нь хүсээгүй жирэмслэлтийн улмаас, 22.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 2.5 хувь нь насанд хүрээгүй хүүхдийн жирэмслэлт их байгаа учраас гэж үзсэн ба өөр ямар шалтгаан байгаа талаархи нээлттэй асуултад манай нийгэмд ажилгүйдэл, ядуурал их байгаагаас, иргэдийн боловсролын түвшин, ухамсар дорой, дүүрэг, хороод муу ажиллаж байгаа, шилжилт хөдөлгөөн их байгаа зэрэг шалтгааныг дурьдсан байна. Үүнийг диаграммаар үзүүлбэл:

График 2



Дээрх респондентуудын хариулсан байдал болон түүнийг дүрсэлсэн диаграммаас бид өнөөдөр монголын нийгэмд ямар учир шалтгааны улмаас хүүхдүүд гэр орноосоо дайжин, гудамжинд тэнэмэл, хараа хяналтгүй байдлаар амьдрах болсон шалтгааныг экспертүүд юу гэж үзэж байгааг харж болохоор байна.

7. Сүүлийн жилүүдэд асрамжийн болон хараа хяналтгүй хүүхдүүдийг хүмүүжүүлэх газар нэлээд олноор бий болж, тэдгээрт хараа хяналтгүй хүүхдүүд харьцангуй тогтвор суурьшилтай амьдарч байгаа боловч зарим хүүхдүүд тэнд тогтохгүй эргэж гудамжинд гарах явдал байсаар байгаа ба үүний шалтгааныг тодруулах зорилгоор тавьсан “Асрамжийн болон хүүхэд хүмүүжүүлэх газраас хүүхдүүд оргож эргээд гудамжинд гарч байгааг Та юутай холбоотой гэж үзэж байна?” гэсэн асуултад респондентуудын 19.3 хувь нь тухайн хүмүүжүүлэх газрын орчин, нөхцөл муу байгаа, 25.4 хувь нь ихэнхи тийм газрууд хоол, унд, орон байраар л хангаж байвал боллоо гэсэн байр сууринаас ханддаг, 47.4 хувь нь зан ааш нь эвдэрчихсэн, хараа хяналтгүй хүүхдүүдтэй өөрсөдтэй нь холбоотой гэж хариулсан ба “Өөр ямар шалтгаан байна гэж Та үзэж байна вэ?” гэсэн нээлттэй асуултад олон жил тэнэмэл амьдралаар амьдарсан хүүхдүүд энэ нь зан үйл болоод хэвшсэн, хүүхдийг хувь хүн талаас нь дэмжих сэтгэл заслын эмчилгээ дутагддаг, асрамжийн болон хүмүүжүүлж буй газрын тус тусын үйл ажиллагаанаас хамаарч байна, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлж чадахгүй байна, хараа хяналтгүй засрах боломжгүй болтлоо зан суртахууны доройтолд орсонтой холбоотой хэмээн үзсэн байна.

Хүснэгт 2.

Асрамжийн болон хүүхэд хүмүүжүүлэх газраас хүүхдүүд оргож эргээд гудамжинд гарч байгааг Та юутай холбоотой гэж үзэж байна?

	Хариулт	Хувиар
1.	Зан ааш нь эвдэрчихсэн, хараа хяналтгүй хүүхдүүдтэй өөрсөдтэй нь холбоотой	47.4
2.	Ихэнхи тийм газрууд хоол, унд, орон байраар л хангаж байвал боллоо гэсэн байр сууринаас ханддаг	25.4
3.	Тухайн хүмүүжүүлэх газрын орчин, нөхцөл муу	19.3
4.	Өөр ямар	7.9

5.	Нийт	100.0

8. “Сүүлийн жилүүдэд хараа хяналтгүй хүүхдийн тоо цөөрсөн болох нь ажиглагддаг. Энэ ямар шалтгаантай гэж Та үзэж байна?” гэсэн асуултад судалгаанд хамрагдагсдын 36.4 хувь нь асрамжийн газар болон бусад буяны байгууллагуудад хүүхдүүд тогтвортой амьдарч байгаа, 8.5 хувь нь эцэг, эхчүүдийн ухамсраас шалтгаалж хүүхдүүдээ хараа хяналтгүй орхих нь багассан, 39.8 хувь нь хүүхдийн болон халамжийн мөнгө өгч байгаатай холбоотой, 15.3 хувь нь хүний наймааны золиос болоод байж магадгүй гэдэг нь ортой байх гэсэн хариултуудыг тус тус сонгосон ба өөр ямар шалтнаан байн вэ? Гэсэн нээлттэй асуултад .

9. Хараа, хяналтгүй хүүхдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудаас авсан экспертийн түвшиний санал асуулгын судалгааны дараагийн бүлэг асуудал нь энэ асуудлаар цаашид ямар арга хэмжээ авах талаар тэдний саналыг тодруулах явдал юм. Энэ үүднээс асуусан “Амьдралын хүнд нөхцөлд байгаа эхэд сэтгэл зүйн зөвөлгөө өгөх төв шаардлагатай эсэх талаар Та юу гэж үздэг вэ?” гэсэн асуултад экспертүүдийн 89.0 хувь нь тийм төв шаардлагатай байна, 2.5 хувь нь шаардлаггүй, 5.9 хувь нь байгаад ч нэмэргүй гэсэн хариултыг сонгожээ. Үүнийг диаграммаар үзүүлбэл:

График 3

10. “Хаягдсан, хараа хяналтгүй хүүхдийг тэжээн тэтгэх ямар хэлбэр илүү үр дүнтэй гэж Та үзэж байна вэ?” гэсэн асуултад респодентуудын 14.5 хувь нь хаягдсан хүүхдийг асрах халамжийн газар байгуулах, 12.0 хувь нь бүтэн өнчин хүүхдийн асрамжийн газарт асран хамгаалах, 58.1 хувь нь гэр бүлд нь буцаах талаар цогц арга хэмжээ авах, 8.5 хувь нь бусдад үрчлүүлэх гэж хариулсан ба өөр ямар хэлбэр байна вэ? гэсэн нээлттэй асуултад эцэг эхийг нь ажилтай болгох сургалтанд хамруулах, асрамжийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх, үе шаттай цогц арга хэмжээ авах зэрэг хариултыг өгсөн байна.

Хүснэгт 3.

“Хаягдсан, хараа хяналтгүй хүүхдийг тэжээн тэтгэх ямар хэлбэр илүү үр дүнтэй гэж Та үзэж байна вэ?”

	Хариулт	хувиар
1.	Гэр бүлд нь буцаах талаар цогц арга хэмжээ авах	58.1
2.	Хаягдсан хүүхдийг асрах халамжийн газар байгуулах,	14.5
3.	Бүтэн өнчин хүүхдийн асрамжийн газарт асран хамгаалах	12.0
4.	Бусдад үрчлүүлэх	8.5
5.	Нийт	100.0

11. “Халамжийн газар байгуулж ажиллахад юуг илүү анхаарах вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогсдын 23.0 хувь нь хаягдсан хүүхдийг эхтэй нь харилцаа холбоотой байлгах, 59.3 хувь нь амьдралд нь тохиолдсон бэрхшээл шийдэгдсэний дараа эхэд нь хүүхдийг эргүүлж өгдөг байх, 3.5 хувь нь хүүхдийг бусдад үрчлүүлдэггүй байх, 14.2 хувь нь нээлттэй асуултыг сонгон бие дааж амьдрах чадвар эзэмшүүлэх, сургуулийг нь завсардуулахгүй байх, асрамжийн газарт удаахгүй байх бодлого барих, гэр бүлд түшиглэсэн хувилбарт үйлчилгээ, хүүхдийг өөртөө итгэлтэй, бие даасан хүн болоход нь удаан хугацаагаар асрамж үзүүлэх зэргийг анхаарахыг санал болгожээ.

Экспертүүдийн бодлоор хүүхдийн хөгжил, хамгаалын салбарт нэн даруй хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагаа, ямар арга хэмжээ байгаа талаар тэдэнд саналаа илэрхийлэх боломж олгох зорилгоор бид 3 нээлттэй асуулт тавьсан. Одоо энэ талаар экспертүүд санаа бодлоо хэрхэн илэрхийлснийг авч үзье.

1. **“Хүүхдийн хөгжил, хамгааллын салбарт нэн даруй өөрчлөх, шинээр баталж гаргах шаардлагатай ямар хууль байна гэж Та боддог вэ? Нэрийг нь бичнэ үү?”** гэсэн нээлттэй асуултад дараахи саналыг илэрхийлсэн байна. Үүнд:

   - Хүүхдийг хүчирхийлсэн болон хүчирхийлэхийг завдсан төрсөн эцэг эх болон, хойд эцэг эхэд нь хуулийн хариуцлагыг оногдуулах, “Гэр бүлийн тухай” хуульд эцэг эхийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, уг хуулийг боловсронгуй болгох
   - Хүн худалдаалах гэмт хэргийн зүйл заалтыг нарийвчлах
   - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон сэтгэцийн эмгэгтэй хүүхдийн эрхийг хамгаалах хуультай болох
   - Хараа хяналтгүй болон хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийн нийгмийн баталгааг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх талаар хуулийн заалтыг боловсронгуй болгох
   - Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг өөрчлөх
   - Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх механизм нь тодорхой бус
   - Хүүхдийн байгууллагын эрх зүйн байдлын тухай
   - Хүүхэд хамгаллын талаар нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх
   - Хүүхдийн хөгжлийг дэмжих тэтгэлэгийн тухай
   - ХЭҮК-ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
   - Өмнө нь батлагдсан хууль тогтоомжуудынхаа хэрэгжилтэнд хяналт тавьж,

хяналт шинжилгээ үнэлгээг тогтмолжуулах

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд төрийн асрамжаас 18 нас хүрээд гарч байгаа хүүхдэд төрөөс 1 удаа тусламж үзүүлдэг гэтэл ТББ , ОУБ-д байгаа хүүхдүүдэд тусламж өгдөггүй. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн адил тэгш эрхтэй байх зааltыг зөрчсөн.
- Асрамжийн үйлчилгээ явуулдаг ТББ тухай хууль
- Хүүхдийн халамжийн төвөөс төгссөн бүтэн өнчин хүүхдүүдэд төрөөс байраар хангах
- Хүүхэд үрчлэх асуудлын зохицуулалтыг боловсронгуй болгох
- Хүүхэд гадаад улс оронд зорчих асуудлыг нарийн хуульчлах
- Сургуулийн өмнөх боловсрол болон сургуулийн хүүхдийн хүмүүжлээс эхлэх. Анхнаас нь суурийг тавиж ажиллахад түлхүү сургалт, семинар зохион байгуулах
- “Хараа хяналтгүй хүүхдүүдэд авах арга хэмжээ”-ийн тухай хууль
- Хүчирхийлэл дарамтанд байгаа хүүхдүүдийг хамгаалах хуулийг баталж гаргах шаардлагатай байна.

2. **“Хүүхдийн хөгжил, хамгааллын салбарт нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай ямар арга хэмжээ байна гэж Та боддог вэ? Нэрийг нь бичнэ үү?”** гэсэн нээлттэй асуултын хариултыг нэгтгэн жагсаавал:
   - Хүүхэд чөлөөт цагаараа хөгжих, хамгаалуулах, дугайлан секц явуулах төвүүдэй байх, ялангуяа захын хороо, хөдөөгийн, алслагдмал, сумдад
   - Гэртээ амьдрах нь хүүхдэд аюултай тохиолдолд хүүхдийг түр болон удаан хугацаагаар байлгах асрамж халамжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж шуурхай арга хэмжээ авах
   - Хороо, хэсэг хүүхдийн гэр бүлийн орчны талаар ажиллах
   - Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
   - Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдаатай болгох
   - Хүүхдийн хамгаллын талаарх хууль тогтоомжуудад энэ чиглэлээр ажиллаж буй ажилтнуудын саналыг авах
   - Хүүхэд хамгаллын стратеги боловсруулах
   - ХХХСҮХ-ийн хугацаа дууссан тул цаашид энэ чиглэлийн хийгдэх бодлого, хөтөлбөр боловсруулж батлуулах
   - Нэн ядуу айлын гоц авиастай хүүхдийг онцгойлон анхаарах
   - Шинээр хөтөлбөр гаргахаас илүү одоо байгаа хөтөлбөрүүдээ үнэлж цаашид илүү сайжруулах арга хэмжээ авах
   - Хүнд нөхцөл амьдарч буй хүүхдүүдийн талаар мэдээллийн бааз бүрдүүлэх, бичиг баримтжуулах
   - Хүүхдүүдтэй ажилладаг хүмүүс ёс зүйн дүрэмтэй болох
   - Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөх өндөр эрсдэл бүхий хүмүүстэй ажиллах чин сэтгэлээсээ туслах эрмэлзлэлтэй сайн дурын болон нийгмийн ажилтнуудыг бэлтгэх
   - Архидалт, мансууруулах бодисоос хол байлгах ба хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилахгүй байх
   - ЕБС-ийн багш нар хүүхдийн хөгжил хамгаалалд идэвхитэй оролцох
   - Хүүхдүүдийг хүнс тэжээлийн сувилал, асрах газруудын витаминаар хангах
   - Хүүхдийн агентлагтай болгох

- ЗГ-ын тухай хуулийг шинэчилж хүүхдийн асуудлыг НХХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд оруулах
- Хүний хөгжлийн мөнгөнөөс болж хүүхдүүдээ буцаан авсан болоод буцаагаад гаргуунд нь хаядагбайдлыг анхаарах
- Иргэдэд хүүхэд хамгааллын ухамсарыг нэмэгдүүлэх
- Насанд хүрсэн хүүхдүүдийн цаашдын амьдралыг шийдвэрлэх талаар
- Хүүхдийн хамгааллыг сайжруулан хөгжүүлэхд гэр бүлрүү асуудлууд руу чиглэсэн арга хэмжээ авах
- Бар, зочид буудал, тоглоомын газруудад хяналт тавьж хүүхдийн хамгааллын асуудлыг сайжруулах
- Нэн ядуу эмзэг бүлгийн гэр бүлийн гишүүдэд сургалтанд хамруулах
- Асрамжийн байгууллагад байдаг хүүхдүүдэд төрөөс олгодог халамжийн үйлчилгээг тодорхой болгох
- Бүтэн өнчин хүүхдүүдүүдийг МСҮТ-д үнэ төлбөргүй хамруулах
- Зан суртахууны доголдолтой буюу засрах төлөвшил үгүй хүүхдүүдийг хагас цэрэгжилтийн байдлаар хүмүүжүүлэх
- Асрамжийн газрын үйл ажиллагаа, хүүхдийн мөнгийг хэрхэн зарцуулж байгааг хянах
- Гэр бүлд нь буцаах арга хэмжээг идэвхжүүлэх
- Цогц бодлого хэрэгтэй байна. Жишээ нь: хүүхэд хөгжил хөтөлбөр шиг
- Шаталсан сургалт шаардлагатай
- Гэр бүлийн салалтыг анхаарах
- Хүүхдийн бие даан, бусдаас хараат бус байх чадвар дадал эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр. Тухайлбал: Эрсдэлт нөхцөлд орвол хэрхэн даван туулах, хаана ямар газруудад хандах гэх мэт
- Хаягдсан, гээгдсэн оюуны сэтгэцийн өөрчлөлттэй хүүхдүүдийн сувилал хэрэгтэй (сэтгэцийн өвчтэй, оюуны хомсдолтой хүүхдийг 16 хүрэхээр дараах шатны шатлалын арга хэмжээ хэрэгтэй байна) 1
- Хүүхдийн хөгжил хамгааллын салбарт ажиллах ажилтны ажлын байрны тодорхойлолтыг тодорхой болгох, мэргэшүүлэх зэрэг болно.

3. “Хүүхдийн хөгжил, хамгааллын салбарын хуулиудаас амьдралд ерөөсөө хэрэгжихгүй байгаа заалтыг нэрлэнэ үү?” гэсэн нээлттэй асуултад Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилт муу, хүүхдийн байгууллагуудын үйл ажиллагаа салангид байгаагаас объектдоо хүрч хэрэгжихдээ муу, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль хэрэгждэггүй, Засаг дарга хүүхдийн хамгааллыг талаар арга хэмжээ авах ажил хангалтгүй, Халамж, асрамж, хамгааллын байгууллагуудад дагж мөрдөх нийтлэг шаардлага гэсэн стандартын зарим зүйл заалтыг өөрчлөх, Эрүүгийн хуулийн 17 бүлэг 117, 119, 120, 1 1 1-р заалтууд хэрэгжихгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.

ХОЁР . ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХИ САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Хорь шахам жилийн өмнөөс анх гудамжинд хоног төөрүүлдэг хараа хяналтгүй хүүхдүүд гарч ирэх болсон. 1990-ээд оны үед 3500 орчим тэнэмэл хүүхдэд бүртгэлтэй байжээ. Сүүлийн жилүүдэд хараа хяналтгүй хүүхдүүдийн тоо буурсан боловч албан бус мэдээллээр одоо нийслэлд 600 гаруй хүүхэд гудамжинд амьдарч байна. Хүүхдүүд гэрээсээ дайжиж, хараа хяналтгүй, тэнэмэл амьдарлаар амьдарч байгаа нь олон шалтгаантай.

Энэ судалгаанд чухам ямар шалтгаан, нөхцлийн улмаас хараа хяналтгүй хүүхдүүд байсаар байгаа, энэ талаар төрийн болон төрийн бус байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ ямар үр дүнтэй байгаа, цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагын мэргэжилтэн, экстертүүдийн саналыг авч дүгнэлт хийхийг зорьсон юм. Ингэхдээ судалгааны санал асуулгаар респондентуудад хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа, хараа хяналтгүй хүүхдийн байдалтай холбоотой 3 бүлэг асуултыг тодруулахаар тавьсан.

Нэгдүгээр бүлэг асуулт нь хүүхдийн талаар явуулж буй төрийн бодлогыг хэрэгжилтийн байдал, хүүхдийн эрхийг хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллаанд үнэлгээ өгөх, хоёрдугаар бүлэг асуулт нь хараа, хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, ямар шалтгааны улмаас гэр орон, эх эцгээсээ дайжин гудамжинд тэнэмэл амьдралаар амьдрах болсон шалтгааныг экспертүүд юу гэж үзэж байгааг тандах, гуравдугаар бүлэг асуулт нь хүүхдийн эрхийг хамгаалах, хараа хяналтгүй хүүхдүүдийн талаар цаашид авах арга хэмжээний талаар экспертүүдийн санаа, бодлыг тодруулах явдал байлаа.

Судалгаанд хамрагдсан экспертүүдийн хариулт, үнэлгээнээс үзэхэд бүхэлдээ манайд хүүхэд хамгааллын салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт дунд зэрэг, тааруухан байна гэсэн үзүүлэлт гарсан байна. Үүнийг төрөөс хүүхдийн хөгжил, хамгааллын талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн сайн биш, дунд зэрэг үнэлгээтэй холбон үзэж болох бөгөөд эдгээр байгууллага болон хараа хяналтгүй хүүхдүүдийг асран халамжилж буй төвүүдийн хоорондын ажлын уялдаа холбоо сайн биш, мөн л дунд зэрэг тааруухан байгаа гэж үзсэн байна. Иймд хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулиар тэдэнд хүлээлгэсэн үүргээ тааруухан биелүүлж байгаагаас үүдэн хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, үйл ажиллагаа сайн биш, манайд хүүхэд хамгааллын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй гэж нийт судалгаанд хамрагдсан мэргэжилтэн, экспертүүдийн **95.7** хувь нь үзсэн байна.

Өнөө үед хүүхдүүд ямар шалтгааны улмаас гэр орон, эх эцгээсээ дайжин гудамжинд тэнэмэл амьдралаар амьдрах болсон шалтгааныг экспертүүд юу гэж үзэж байгааг тандсан асуултад судалгаанд оролцогсдын талаас илүү хувь нь буюу 57.8 хувь нь хүүхдээ тэжээн тэтгэх эдийн засгийн боломжгүйгээс, 22.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэж үзсэн ба өөр бусад буюу манай нийгэмд ажилгүйдэл, ядуурал их байгаа, иргэдийн боловсролын түвшин, ухамсар дорой, дүүрэг, хороод муу ажиллаж байгаа, шилжилт, хөдөлгөөн их байгаа зэрэг шалтгааныг дурьдсан байна. Эндээс хүүхэд тэнээд байгаа хэд хэдэн хүчин зүйл байна гэсэн дүгнэлт хийж болно. Нэгдүгээрт, манай нийгэмд нүүрлэсэн, олон нийтийн санааг зовоож буй асуудал болох ажилгүйдэл ядуурал, архидалт үүний нэг гол үндсэн шалтгаан болж байна гэж үзэж болно. Эцэг эх нь архи ууж, агсам тавьдаг тул хүүхдүүд гэрээсээ дайжих гол шалтгаан болдог аж.

Гудамжинд олон сараар амьдарснаас болж хүүхдүүд бусадтай зүй зохисгүй харьцах, мөн хулгай дээрэм хийж эхэлдэг байна. Бас нэг шалтгаан нь нийгэмд байгаа анхаарвал зохих асуудал болох гэр бүл салалт, ар гэр нь салж нийлээд өөр эцэг эхтэй болон гэр бүлийнхэнтэйгээ таарахаа болиод хуучин эцэг эхийн дунд завсардаад гудамжинд гарсан хүүхэд олон байна. Энэ мэт сөрөг байдал нь хүүхдийг хараа хяналтгүй гадуур тэнэх шалтаг шалтгаан болж РС тоглоомын газраар явж, тоглоомдоо өөрсдөө донтон, адал явдалтай кино үзээд түүндээ итгэн, тэр байдал нь өөрсдөд нь сайхан мэт санагдаад энэ замыг сонгоод явж байгаа хүүхдүүд ч байдаг байна. Иймд хүүхдүүдийг нийгэмшүүлэх нь хамгийн чухал болохыг мэргэжилтнүүд онцолж байна.

Сүүлийн жилүүдэд хараа хяналтгүй хүүхдийн тоо цөөрсөн болох нь дээр дурьдсан мэдээллээс харагдаж байна. Энэ ямар шалтгаантай болохыг экспертүүдээс тодруулахад

хамгийн олон хүн буюу 39.8 хувь нь хүүхдийн болон халамжийн мөнгө өгч байгаатай холбон үзсэн бол 36.4 хувь нь асрамжийн газар болон бусад буяны байгууллагуудад хүүхдүүд тогтвортой амьдарч байгаа учраас гэсэн хариултыг сонгожээ. Хараа хяналтгүй хүүхдийн тоо цөөрснийг экспертүүдийн дийлэнхи нь эх эцэг нь халамжийн мөнгө авахын тулд гэр бүлдээ буцааж авсан, халамжийн газар тогтвортой амьдарч байгаа гэж үзсэн хэдий ч тэдний 15.3 хувь нь тэнэмэл гэгдэх хүүхдүүд цөөрсөн шалтгааныг хүний наймааны золиос болоод байгаа гэдэг нь үнэн байх гэж үзсэнийг анхаарах шаардлагатай мэт санагдана.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд асрамжийн болон хараа хяналтгүй хүүхдүүдийг хүмүүжүүлэх газар нэлээд олноор бий болж, тэдгээрт хараа хяналтгүй хүүхдүүд харьцангуй тогтвор суурьшилтай амьдарч байгаа боловч зарим хүүхдүүд тэнд тогтохгүй эргэж гудамжинд гарч байгаагийн шалтгааныг мэргэжилтэнүүд нэг талаар, зан ааш нь эвдэрчихсэн, хараа хяналтгүй хүүхдүүдтэй өөрсөдтэй нь холбоотой гэж үзсэн ч нөгөө талаар, ийм хүмүүжүүлэх газрын орчин, нөхцөл муу, хоол, унд, орон байраар л хангаж байвал боллоо гэсэн байр сууринаас ханддаг нь гэр бүлийг орлож чадахгүй байгаатай холбоотой гэж үзсэн байна.

Дээрхи дүгнэлт хаягдсан, хараа хяналтгүй хүүхдийг тэжээн тэтгэх ямар хэлбэр илүү үр дүнтэй болох талаар экспертүүдийн сонгосон хариултаар батлагдаж байгаа юм. Тэдний олонхи нь буюу 58.1 хувь нь ийм хүүхдүүдийг гэр бүлд нь буцаах талаар цогц арга хэмжээ авах шаардлагатай байна гэж үзжээ.

Мөн халамжийн газар байгуулан ажиллуулахад юуг анхаарвал зохих талаар судалгаанд оролцогсод саналаа илэрхийлэхдээ хаягдсан хүүхдийг эхтэй нь харилцаа холбоотой байлгах, амьдралд нь тохиолдсон бэрхшээл шийдэгдсэний дараа эхэд нь хүүхдийг эргүүлж өгдөг байх нь зүйтэй гэснээс үзэхэд экспертүүд гэр бүлд л хүүхэд хүмүүжих орчин нөхцөл бүрэн дүүрэн бүрдэнэ гэж үзэж байгааг харуулж байна. Хараа хяналтгүй хүүхдийг бусдад үрчлүүлэхийг судалгаанд оролцогсод төдийлөн дэмжээгүй байдал харагдаж байгаа юм.

Хүүхдийг гэр бүлд нь халуун дулаан уур амьсгал, хайр энэрлээр хүмүүжүүлэхийн тулд амьдралын хүнд нөхцөлд байгаа эхэд энэ байдлыг даван туулах сэтгэлийн тэнхээ олгох зорилгоор сэтгэл зүйн зөвөлгөө өгөх Төв байгуулах нь зөв гэдгийг судалгаанд хамрагдагсдын 89 хувь нь дэмжсэн байна.

Хүүхдийн эрхийн хамгаалал, хараа хяналтгүй хүүхдийн талаар цаашид авах арга хэмжээний талаар экпертүүд маш олон санал гаргасныг нэгтгэн дурьдвал:

- Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилт муу, хүүхдийн байгууллагуудын үйл ажиллагаа салангид байгаагаас объектдоо хүрч хэрэгжихдээ муу, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль хэрэгждэггүй, Засаг дарга хүүхдийн хамгааллыг талаар арга хэмжээ авах ажил хангалтгүй байгааг санууллж байна,
- “Гэр бүлийн тухай” хуульд эцэг эхийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, уг хуулийг боловсронгуй болгох, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг өөрчлөх, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах, хэрэгжүүлэх механизмыг тодорхой болгох, Хүүхдийн байгууллагын эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулах, Асрамжийн үйлчилгээ явуулдаг ТББ тухай хуультай болох
- Хүүхэд хамгааллын талаар нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, хүүхэд хамгааллын стратеги боловсруулах , хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдаатай болгох
- Хүүхдүүдтэй ажилладаг ажилтнуудын ёс зүйн дүрэмийг бий болгох, хүүхдийн хөгжил, хамгааллын салбарт ажиллах ажилтны ажлын байрны тодорхойлолтыг тодорхой болгох, мэргэшүүлэх, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон өртөх өндөр эрсдэл бүхий хүмүүстэй ажиллах чин сэтгэлээсээ туслах эрмэлзлэлтэй

сайн дурын болон нийгмийн ажилтнуудыг бэлтгэх

- Нэгэнт ядуурал бодитой оршиж байгаа нөхцөлд нэн ядуу айлын гоц авъяастай хүүхдийг онцгойлон анхаарах, хүнд нөхцөл амьдарч буй хүүхдүүдийн талаар мэдээллийн бааз бүрдүүлэх, бичиг баримтжуулах
- Хараа хяналтгүй хүүхдүүдийг гэр бүлд нь буцаах арга хэмжээг идэвхжүүлэх, энэ талаар цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх зэрэг болно.

ХАВСРАЛТ 1.

“ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ” СЭДЭВТ СУДАЛГААНЫ ЭКСПЕРТИЙН САНАЛ АСУУЛГЫН ДАН ТООЛОЛТЫН ДҮН

№	Асуулт	Хариулт	Тоо	Хувь
1.	Хүүхэд хамгаллын салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх тайлан мэдээлэлтэй танилцах бололцоо Танд хэр зэрэг байдаг вэ?	Бүрэн боломжтой	36	30.8
		Хөөцөлдөж байж л танилцах боломжтой	57	48.7
		Бараг боломжгүй дээ	16	13.7
		Тийм боломж ерөөсөө байхгүй	6	5.1
		Мэдэхгүй юм	2	1.7
	• Бүгд		117	100%
2.	Хүүхэд хамгаллын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилт ерөнхийдөө ямар байна гэж Та боддог вэ?	Хэрэгжилт сайн байгаа	9	7.6
		Дунд зэрэг	55	46.6
		Тааруухан	39	33.1
		Муу байгаа	8	6.8
		Мэдэхгүй	7	5.9
	• Бүгд		118	100%
4.	Таны бодлоор хараа хяналтгүй хүүхдийг халамжлах төвүүд, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага хоёрын ажлын уялдаа холбоо ямар байдаг вэ?	Сайн байгаа	18	15.7
		Дунд зэрэг	36	31.3
		Тааруухан	37	32.2
		Муу байгаа	18	15.7
		Мэдэхгүй	6	5.2
	• Бүгд		115	100%
5.	Хүүхэд хамгаллын салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх талаар дараахь байгууллагууд хэр ажиллаж байна гэж Та үзэж байна вэ?			

5.1	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар	Сайн ажиллаж байна	20	17.9
		Дунд зэрэг ажиллаж байна	45	40.2
		Тааруухан ажиллаж байна	28	25.0
		Маш муу ажилладаг	10	8.9
		Мэдэхгүй	9	8.0
	• Бүгд		112	100%
5.2	Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар	Сайн ажиллаж байна	12	10.8
		Дунд зэрэг ажиллаж байна	36	32.4
		Тааруухан ажиллаж байна	37	33.3
		Маш муу ажилладаг	14	12.6
		Мэдэхгүй	12	10.8
	• Бүгд		111	100%
5.3	Дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар	Сайн ажиллаж байна	13	11.6
		Дунд зэрэг ажиллаж байна	30	26.8
		Тааруухан ажиллаж байна	40	35.7
		Маш муу ажилладаг	21	18.8
		Мэдэхгүй	8	7.1
	• Бүгд		112	100%
5.4	Нийслэлийн хүүхдийн төлөө газар	Сайн ажиллаж байна	37	33.6
		Дунд зэрэг ажиллаж байна	41	37.3
		Тааруухан ажиллаж байна	21	19.1
		Маш муу ажилладаг	8	7.3
		Мэдэхгүй	3	2.7
			110	100%
5.5	Нийслэлийн хүүхдийн халамж үйлчилгээний төв	Сайн ажиллаж байна	24	21.1
		Дунд зэрэг ажиллаж байна	46	40.4
		Тааруухан ажиллаж байна	21	18.4
		Маш муу ажилладаг	10	8.8
		Мэдэхгүй	13	11.4
	Бүгд		114	100%

5.6	Цагдаагийн байгууллага	Сайн ажиллаж байна	36	31.9
		Дунд зэрэг ажиллаж байна	49	43.4
		Тааруухан ажиллаж байна	20	17.7
		Маш муу ажилладаг	5	4.4
		Мэдэхгүй	3	2.7
	Бүгд		113	100%
5.7	Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ	Сайн ажиллаж байна	33	28.9
		Дунд зэрэг ажиллаж байна	44	38.6
		Тааруухан ажиллаж байна	13	11.4
		Маш муу ажилладаг	7	6.1
		Мэдэхгүй	17	14.9
	Бүгд		114	100%
6.	Манай улсад хүүхдийн эрх олон хэлбэрээр зөрчигдөж байгаа нь манайд хүүхэд хамгааллын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байгааг харуулж байна гэдэгтэй Та санал нийлэх үү?	Санал бүрэн нийлнэ.	53	45.3
		Санал нийлнэ.	59	50.4
		Санал нийлэхгүй.	5	4.3
	Бүгд		117	100%
7.	Эх хүн үр хүүхдээ ямар шалтгаанаас болж гудамжинд хаядаг гэж Та үздэг вэ?	Хүүхдээ тэжээн тэтгэх эдийн засгийн боломжгүйгээс	68	57.6
		Хүсээгүй жирэмслэлтийн улмаас	21	17.8
		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	26	22.0
		Насанд хүрээгүй хүүхдийн жирэмслэлт их байгаа учраас	3	2.5
	• Бүгд		194	100%
8.	Амьдралын хүнд нөхцөлд байгаа эхэд сэтгэл зүйн зөвөлгөө өгөх төв шаардлагатай эсэх талаар Та юу гэж үздэг вэ?	Шаардлагатай	105	89.0
		Шаардлагагүй	3	2.5
		Байгаад ч нэг их нэмэргүй	7	5.9
		Мэдэхгүй	3	2.5
	• Бүгд		118	100%

9.	Хаягдсан, хараа хяналтгүй хүүхдийг тэжээн тэтгэх ямар хэлбэр илүү үр дүнтэй гэж Та үзэж байна вэ?	Хаягдсан хүүхдийг асрах халамжийн газар байгуулах	17	14.5
		Бүтэн өнчин хүүхдийн асрамжийн газарт асран хамгаалах	14	12.0
		Бусдад үрчлүүлэх	10	8.5
		Гэр бүлд нь буцаах талаар цогц арга хэмжээ авах	68	58.1
		Өөр ямар	8	6.8
	• Бүгд		117	100%
10.	Халамжийн газар байгуулж ажиллахад юуг илүү анхаарах вэ?	Хаягдсан хүүхдийг эхтэй нь харилцаа холбоотой байлгах	26	23.0
		Амьдралд нь тохиолдсон бэрхшээл шийдэгдсэний дараа эхэд нь хүүхдийг эргүүлж өгдөг байх	67	59.3
		Хүүхдийг бусдад үрчлүүлэхгүй байх	4	3.5
		Өөр ямар	16	14.2
	• Бүгд		113	100%
11.	Сүүлийн жилүүдэд хараа хяналтгүй хүүхдийн тоо цөөрсөн болох нь ажиглагддаг. Энэ ямар шалтгаантай гэж Та үзэж байна?	Асрамжийн газар болон бусад буяны байгууллагуудад хүүхдүүд тогтвортой амьдарч байгаа	43	36.4
		Эцэг, эхчүүдийн ухамсраас шалтгаалж хүүхдүүдээ хараа хяналтгүй орхих нь багассан	10	8.5
		Хүүхдийн болон халамжийн мөнгө өгч байгаатай холбоотой	47	39.8
		Хүний наймааны золиос болоод байж магадгүй гэдэг нь ортой байх	18	15.3
	• Бүгд		118	100%
12.	Асрамжийн болон хүүхэд хүмүүжүүлэх газраас хүүхдүүд оргож эргээд гудамжинд гарч байгааг Та юутай холбоотой гэж үзэж байна?	Тухайн хүмүүжүүлэх газрын орчин, нөхцөл муу байгаатай холбоотой	22	19.3
		Ихэнхи тийм газрууд хоол, унд, орон байраар л хангаж байвал боллоо гэсэн байр сууринаас ханддагтай холбоотой	29	25.4
		Зан ааш нь эвдэрчихсэн, хараа хяналтгүй хүүхдүүдтэй өөрсөдтэй нь холбоотой	54	47.4
		Өөр ямар	9	7.9
	Бүгд		114	100%

16.	Таны хүйс	Эрэгтэй	25	22.1
		Эмэгтэй	87	77.0
	Бүгд		113	100%
17.	Таны мэргэжил	Нийгмийн ажилтан	34	33.0
		Багш	31	30.1
		Эмч	4	3.9
		Эрх зүйч	25	24.3
		Сэтгэл зүйч	4	3.9
		Эдийн засагч	5	4.9
	Бүгд		104	100%
18.	Ажил, албан тушаал	Менежер	21	20.0
		Хүүхдийн байцаагч	14	13.3
		Нийгмийн ажилтан	44	41.9
		Хөтөлбөрийн зохицуулагч	5	4.8
		Багш	13	12.4
		Эмч	1	1.0
		Асран хүмүүжүүлэгч ээж	5	4.8
		Халамжийн ажилтан	2	1.9
	Бүгд		105	100%

* * *

ХАВСРАЛТ 2.

“ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ” СЭДЭВТ СУДАЛГААНЫ ЭКСПЕРТИЙН САНАЛ АСУУЛГА

- Таны энэ өдрийн амар амгаланг айлтгая. УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны захиалгаар УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвөөс хийж буй энэхүү судалгаанд мэргэжлийн экспертээр оролцохыг урьж байна. Та анкетийн асуултуудыг анхааралтай уншаад өөрийн санаанд нийцсэн хариултын өмнөх дугаарыг дугуйлах буюу сул орхисон зайнд санал бодлоо чөлөөтэй илэрхийлнэ үү. Таны мэдээллийг зөвхөн судалгааны зориулалтаар ашиглах болно.
- Бидний судалгааны ажилд оролцож хамтран ажилласан Танд талархлаа илэрхийлье

1. Хүүхэд хамгааллын салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх тайлан мэдээлэлтэй танилцах боломжоо Танд хэр зэрэг байдаг вэ?

2. Бүрэн боломжтой
3. Хөөцөлдөж байж л танилцах боломжтой
4. Бараг боломжгүй дээ
5. Тийм боломж ерөөсөө байхгүй
6. Мэдэхгүй юм

2. Хүүхэд хамгааллын салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилт ерөнхийдөө ямар байна гэж Та боддог вэ?

1. Хэрэгжилт сайн байгаа
2. Дунд зэрэг
3. Тааруухан
4. Муу байгаа
5. Мэдэхгүй

3. Нийт улсын болон танай байгууллагын хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр хамгийн үр дүнтэй хэрэгжсэн, одоо хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү.

……..

……....

……..

4. Таны бодлоор хараа хяналтгүй хүүхдийг халамжлах төвүүд, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага хоёрын ажлын уялдаа холбоо ямар байдаг вэ?

1. Сайн байгаа
2. Дунд зэрэг
3. Тааруухан
4. Муу байгаа
5. Мэдэхгүй

5. Хүүхэд хамгааллын салбарт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх талаар дараахь байгууллагууд хэр ажиллаж байна гэж Та үзэж байна вэ?

Байгууллагуудын нэр	Үйл ажиллагааны үнэлгээ				
	Сайн ажиллаж байна	Дунд зэрэг ажиллаж байна	Тааруухан ажиллаж байна	Маш муу ажиладаг	Мэдэхгүй
• ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар	1	2	3	4	5

• Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар	1	2	3	4	5
• Дүүргийн Засаг дарга, түүний Тамгын газар	1	2	3	4	5
• Нийслэлийн хүүхдийн төлөө газар	1	2	3	4	5
• Нийслэлийн хүүхдийн халамж үйлчилгээний төв	1	2	3	4	5
• Цагдаагийн байгууллага	1	2	3	4	5
• Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ	1	2	3	4	5

* * *

6. Манай улсад хүүхдийн эрх олон хэлбэрээр зөрчигдөж байгаа нь манайд хүүхэд хамгааллын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байгааг харуулж байна гэдэгтэй Та санал нийлэх үү?

1. Санал бүрэн нийлнэ.
2. Санал нийлнэ.
3. Санал нийлэхгүй.

7. Эх хүн үр хүүхдээ ямар шалтгаанаас болж гудамжинд хаядаг гэж Та үздэг вэ?

1. Хүүхдээ тэжээн тэтгэх эдийн засгийн боломжгүйгээс
2. Хүсэзгүй жирэмслэлтийн улмаас
3. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас
4. Насанд хүрээгүй хүүхдийн жирэмслэлт их байгаа учраас
5. Өөр ямар .....

8. Амьдралын хүнд нөхцөлд байгаа эхэд сэтгэл зүйн зөвөлгөө өгөх төв шаардлагатай эсэх талаар Та юу гэж үздэг вэ?

1. Шаардлагатай
2. Шаардлагагүй
3. Байгаад ч нэг их нэмэргүй
4. Мэдэхгүй

9. Хаягдсан, хараа хяналтгүй хүүхдийг тэжээн тэтгэх ямар хэлбэр илүү үр дүнтэй гэж Та үзэж байна вэ?

1. Хаягдсан хүүхдийг асрах халамжийн газар байгуулах
2. Бүтэн өнчин хүүхдийн асрамжийн газарт асран хамгаалах
3. Бусдад үрчлүүлэх
4. Гэр бүлд нь буцаах талаар цогц арга хэмжээ авах
5. Өөр ямар .....

10. Халамжийн газар байгуулж ажиллахад юуг илүү анхаарах вэ?

1. Хаягдсан хүүхдийг эхтэй нь харилцаа холбоотой байлгах
2. Амьдралд нь тохиолдсон бэрхшээл шийдэгдсэний дараа эхэд нь хүүхдийг эргүүлж өгдөг байх
3. Хүүхдийг бусдад үрчлүүлэхгүй байх
4. Өөр ямар .....

11. Сүүлийн жилүүдэд хараа хяналтгүй хүүхдийн тоо цөөрсөн болох нь ажиглагддаг. Энэ ямар шалтгаантай гэж Та үзэж байна?

1. Асрамжийн газар болон бусад буяны байгууллагуудад хүүхдүүд тогтвортой амьдарч байгаа
2. Эцэг, эхчүүдийн ухамсраас шалтгаалж хүүхдүүдээ хараа хяналтгүй орхих нь багассан
3. Хүүхдийн болон халамжийн мөнгө өгч байгаатай холбоотой
4. Хүний наймааны золиос болоод байж магадгүй гэдэг нь ортой байх
5. Өөр ямар.....

12. Асрамжийн болон хүүхэд хүмүүжүүлэх газраас хүүхдүүд оргож эргээд гудамжинд гарч байгааг Та юутай холбоотой гэж үзэж байна? Тухайн хүмүүжүүлэх газрын орчин, нөхцөл муу байгаатай холбоотой

1. Ихэнхи тийм газрууд хоол, унд, орон байраар л хангаж байвал боллоо гэсэн байр сууринаас ханддагтай холбоотой
2. Зан ааш нь эвдэрчихсэн, хараа хяналтгүй хүүхдүүдтэй өөрсөдтэй нь холбоотой
3. Өөр ямар.....

13. Хүүхдийн хөгжил, хамгааллын салбарт нэн даруй шинээр баталж хэрэгжүүлэхшаардлагатай ямар арга хэмжээ байна гэж Та боддог вэ? Нэрийг нь бичнэ үү?

.....

.....

.....

.....

14. Хүүхдийн хөгжил, хамгааллын салбарт нэн даруй өөрчлөх, шинээр баталж гаргах шаардлагатай ямар хууль байна гэж Та боддог вэ? Нэрийг нь бичнэ үү?

.....

.....

.....

.....

15. Хүүхдийн хөгжил, хамгаллын салбарын хуулиудаас амьдралд ерөөсөө хэрэгжихгүй байгаа заалтыг нэрлэнэ үү?

.....

.....

.....

.....

16. Таны хүйс:

- Эрэгтэй
- Эмэгтэй

17. Таны мэргэжил

18. Ажил, албан тушаал